


ЗАЛУУЧУУДЫН ЭЦЭГ ЭХ,  
УДИРДАГЧДАД  
ЗОРИУЛСАН  
УДИРДАМЖ





© 2001 by Intellectual Reserve, Inc.  
Бүх эрх хамгаалагдсан.  
АНУ-д хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 1/04  
Орчуулгын зөвшөөрөл: 1/04  
*Guidebook for Parents and Leaders of Youth (International Version)*-ын орчуулга  
Mongolian

## А Г У У Л Г А

Тэргүүн Зөвлөлийн Захиас . . . . .	1
Эцэг Эхийн Үүрэг . . . . .	3
Удирдагчдын Үүрэг . . . . .	5
Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө . . . . .	7
Бурханы Өмнө Хүлээсэн Аароны Санваартны Үүргийн Хөтөлбөр . . . . .	9
Тойм . . . . .	9
Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Үйлчлэлийн Төсөл . . . . .	11
Харилцан Сайжралтад Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Үйл Ажиллагааууд . . . . .	11
Скаут . . . . .	11
Гэрчилгээнүүд ба Шагнал . . . . .	12
Бүртгэл Хөтлөлт . . . . .	13
Хувь Хүний болон Бүс Нутгийн Хэрэгцээнд Нийцүүлэх нь . . . . .	13
Удирдагчдын Үүрэг Хариуцлага . . . . .	14
Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөр . . . . .	15
Тойм . . . . .	15
Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Туршлага ба Төслүүд . . . . .	17

Харилцан Сайжралт дахь Хувийн Өсөлтийн Үйл Ажиллагаанууд . . . . .	18
Эмблем, Гэрчилгээ ба Батламж . . . . .	18
Удирдагчдын Хувийн Өсөлтийн Шаардлагууд . .	19
Хувь Хүний болон Орон Нутгийн Хэрэгцээнд Нийцүүлэх нь . . . . .	19
Удирдагчдын Үүрэг Хариуцлага . . . . .	20
Харилцан Сайжралт . . . . .	22
Зорилго . . . . .	22
Төлөвлөлт. . . . .	22
Харилцан Сайжралтын Бүтэц ба Давтамж . . . . .	23
Жил Тутмын Уриа . . . . .	25
Нэмэлт Эх Сурвалжууд . . . . .	25
Удирдлагын Зарчмуудыг Залуучуудад Заах нь. . . . .	27

Энэ удирдамжин дахь *гадасны ерөнхийлөгч, бишоп* гэсэн хэллэгүүд нь мөн *дүүргийн ерөнхийлөгч, салбарын ерөнхийлөгч* хэмээн, *гадас, хэсэг* гэсэн хэллэгүүд нь мөн *дүүрэг, салбар* хэмээн хэрэглэгдэнэ.

## ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС

Залуучуудын Хүндэт Эцэг Эхчүүд, Удирдагчид аа:

**Б**ид Сүмийнхээ залуучуудад хайртай. Бид Тэнгэрлэг Эцэгийнхээ гарамгай охид хөвгүүдийг маш ихээр хүндлэн биширдэг. Тэд бол энэ Сүмийн ирээдүйн эцэг эхчүүд, удирдагчид билээ. Бидний залбирал нь эцэг эхчүүд, удирдагчдын хувьд бид тэднийг Есүс Христийн сайн мэдээнд үнэнч, итгэлтэй үлдэхэд туслахын төлөө байдаг.

Бид Сүмийн залуу хүмүүсийг зоригтой, шийдэмгий, үнэнч шударга Бурханы үйлчлэгчид байж өдөр тутмынхаа амьдралыг зориулснаар ариун сүм рүү явж тэдэнд зориулсан Бурханы хамгийн агуу адислалуудыг хүлээн аваасай хэмээн хүсдэг. Тиймээс бид Сүмийн залуучуудад зориулж ариун сүмийг бэлэгдэл болгон сонгон авсан юм.

*Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө; Аароны Санваартан: Бурханы Өмнө Хүлээсэн Үүргээ Биелүүлэх нь; Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшил* зэрэг номнууд нь Тэнгэрлэг Эцэгийн тэднийг юу хийж, ямар байгаасай хэмээсэн хүслийг ойлгоход залуу эрэгтэйчүүд ба залуу

эмэгтэйчүүдэд тусалдаг. Эдгээр номнууд нь та бүхэнд эцэг эхчүүд ба удирдагчдын хувьд залуу-чуудад ариун сүмийн индаумент хүртэх, номлолд явах, ариун сүмийн гэрлэлт болон эцэг эх болоход нь бэлтгэхэд туслах эх сурвалж болж өгдөг.

Бид залуу эрэгтэй бүрийг Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Шагналыг хүртэнэ гэж найдаж байна. Бид залуу эмэгтэй бүрийг Залуу Эмэгтэйчүүдийн Батламжийг хүртэнэ гэж найдаж байна. Эдгээр шагналыг хүртэх шаардлагууд нь хүч чадал сорьсон бөгөөд үр өгөөжтэй юм. Үүнийг биелүүлэхэд нь залуучуудад тусалдаг эцэг эхчүүд болон удирдагчиддаа бид талархаж байна. Сүмийн залуучуудыг хүлээж буй агуу үүрэг хариуцлагуудтайгаа нүүр учрахад нь туслахад Их Эзэн та бүгдийг адислах болтугай.

Тэргүүн Зөвлөл

## ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ҮҮРЭГ

Таны охид хөвгүүд нь агуу их чадамжтай Бурханы хүүхдүүд билээ. Хэдийгээр Сүмд тэдэнд туслах олон удирдагч болон нөөц баялгууд байдаг боловч та бүхэн эцэг эхийн хувьд тэднийг амжилт гаргахад нь туслах үндсэн үүрэг хариуцлагатай. Энэхүү удирдамжинд өгүүлсэн залуучуудад зориулсан Сүмийн хөтөлбөрүүд болон материалууд нь та бүхнийг үр хүүхдүүдийнхээ амжилт гаргахад нь хэрэгтэй чадвар, зан чанарыг хөгжүүлэхэд туслах зорилгоор бүтээгдсэн юм.



Дараах нь та бүхэнд охид хөвгүүдийг тань Сүмийн залуучуудын хөтөлбөрүүд болон материалуудаас хамгийн агуу тусламж хүлээн авахад тусалж чадах зарим замууд юм:

- Энэхүү удирдамжинд буй мэдээлэлтэй танил болох.
- *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөөг* тэдэнтэй хамт давтах. Дикон, багш, мөн санваартнуудад зориулсан *Аароны Санваартан: Бурханы Өмнө Хүлээсэн Үүргээ Биелүүлэх* нь удирдамжийг хөвгүүдтэйгээ хамт давтах. *Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшил* удирдамжаас охидтойгоо хамт давтах.



- Охид хөвгүүдээ Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Шагнал болон Залуу Эмэгтэйчүүдийн Батламжийн төлөө ажиллахад нь тэдний хүч чадлыг сорихуйц зорилго тавьж түүнийгээ биелүүлэхэд нь туслах. Та бүхний зөвшөөрөлтэйгөөр тэд өөрсдийнх нь хувийн хэрэгцээ, сонирхолд нийцэх олон шаардлагыг бий болгож чадна.
- Охид хөвгүүдтэйгээ тэдний өсөлтийнх нь талаар ярилц. Тэднийг зорилго эсвэл төлөвлөгөөгөө биелүүлэх бүрт хүч чармайлтыг нь магтан сайшааж *Аароны Санваартан: Бурханы Өмнө Хүлээсэн Үүргээ Биелүүлэх нь болон Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшил* зэрэг номнууд дээр тохирох газарт гарын үсгээ зурж бай.
- Хүүхдүүдийнхээ Аароны Санваар эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчидтай ярилц. Эдгээр удирдагч охид хөвгүүдийг хүчирхэгжүүлэхэд туслах Мючелийн болон бусад чуулга, ангийн үйл ажиллагаанууддаа юу хийдгийг та суралц. Хүүхдүүдээ Мючелийн үйл ажиллагаанд долоо хоног бүр оролцохыг дэмж.
- Боломжтой бол та охид хөвгүүдийнхээ шагнал гардах Сүмийн залуучуудын арга хэмжээнүүдэд оролц.
- Охид хөвгүүдээ семинарт оролцохыг дэмж.

## УДИРДАГЧДЫН ҮҮРЭГ

**З**алуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн удирдагчийн хувьд та тэднийг Есүс Христийн сайн мэдээг суралцах, гэрчлэлээ хөгжүүлэх, мөн Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Шагнал ба Залуу Эмэгтэйчүүдийн Батламжийг хүртэх үүргээ



биелүүлэхэд нь туслах амин чухал үүрэгтэй. Таны үлгэр жишээч байдал, урам зориг болон анхаарал халамж нь тэдний амьдралын энэ чухал үед залуучуудад үнэлж баршгүй ач тустай. Залуу эрэгтэй, эмэгтэй бүрийн талаар, мөн тэдэнд хамгийн сайнаар яаж тусалж чадахыг суралц.

Сүмийн залуучуудын хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг Сүмийн Зааварчилгаануудын Удирдамжийн (Church Handbook of Instructions) 2-р номноос: *Priesthood and Auxiliary Leaders* сэдвийг үзэж болно. Энэ удирдамж нь дараах мэдээллүүдийг агуулдаг:

- Аароны Санваартнаас Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Хөтөлбөр ба Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөр болох залуучуудад зориулсан Сүмийн амжилтын хөтөлбөрүүдийн гол санаа.
- Харилцан Сайжралтын үйл ажиллагааны талаар илүү нарийвчилсан мэдээлэл.

- Залуучуудын удирдлагыг хэрхэн хөгжүүлэх тухай мэдээлэл.

Бид та бүхнийг ийнхүү уриалж байна:

- Энэхүү удирдамж дахь мэдээллийг анхааралтай унших.
- Залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг адисалж хүчирхэгжүүлэхийн төлөө эцэг эхчүүдтэй хамтран ажиллах.

Та Залуу Эрэгтэйчүүд, Эмэгтэйчүүдийн хөтөлбөрт элсэн орж буй залуучуудтай анх уулзахдаа, тэдний эцэг эхчүүдэд энэ удирдамжийн хувийг өгч үүнийг уншихад урамшуул.



Залуучуудын үйл ажиллагааны талаар эцэг эхчүүдэд байнга мэдээлж тохиромжтой үед нь тэднийг оролцуулахаар урих.

- *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* удирдамжийг уншиж, өөрийнхөө амьдралын жишгүүдэд хэрэглэх. Залуучуудад эдгээр жишгүүдээс зааж чадах бүгдийг заа.
- Хэрэв та залуу эрэгтэйчүүдийн удирдагч бол дикон, багш ба санваартнуудад зориулсан *Аароны Санваартан: Бурханы Өмнө Хүлээсэн Үүргээ Биелүүлэх* нь гэсэн удирдамжуудтай танилцах. Хэрэв та залуу эмэгтэйчүүдийн удирдагч бол *Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшил* номтой танилцах хэрэгтэй.

## ЗАЛУУЧУУДЫН БАТ БӨХ БАЙДЛЫН ТӨЛӨӨ

**З**алуучуудын *Бат Бөх Байдлын Төлөө* нь Сүмийн Тэргүүн Зөвлөлөөс залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд өгсөн зааварчилгаа юм. Энэ нь залууст Сүмийн жишгүүдийг танилцуулж, тэдгээрт хэрхэн хандах талаар заадаг. Энэ нь залуучуудад амьдралынх нь аянд тэднийг хүчирхэгжүүлж удирдах баттай чиглэлийг өгдөг. Залуучууд нь эдгээр жишгүүдийг дагаснаар Сүм болон дэлхийд агуу үйлчлэгчид нь байж ариун ёслолуудыг хүртэхээр ариун сүм рүү явах зөв зохистой байх болно.

Залуу эрэгтэй болон залуу эмэгтэй бүр *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* гарын авлагаас нэг хувийг авсан байх ёстой. Тэд тэдгээр жишгүүдийг дахин давтаж тэдгээрийн дагуу хэрхэн сайн амьдрахаа бодоход нь тэдэнд урам зориг өгөх ёстой.

Эцэг эхийн хувьд та нар бас энэхүү товхимлын нэг хувийг авах ёстой. Үүнийг суралцаж жишгүүд болон зарчмуудын талаар охид, хөвгүүдтэйгээ ярилц.



Жишгүүдийг ярилцахаар гэр бүлийн үдшээ төлөвлө. Өөрсдөө жишгүүдийн дагуу амьдар. Та нарын үлгэр жишээ чинь үүний дагуу амьдрахад хүүхдүүдэд тань маш их туслах болно.

Хэрэв та удирдагч бол тэрхүү товхимол дахь жишгүүдийг судлах ёстой. Тэднийг хичээлүүд, чуулга болон ангийн үйл ажиллагаануудад бататгах замыг эрж хай. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* нь Харилцан Сайжралтын үйл ажиллагаануудыг төлөвлөх үндсэн эх сурвалж юм.



# ААРОНЫ САНВААРТНААС БУРХАНЫ ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХӨТӨЛБӨР

## Тойм

**А**ароны Санваартнаас Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Хөтөлбөр нь залуу эрэгтэйчүүдэд Аароны Санваартныхаа үүргийг биелүүлэхэд тусалдаг. Энэ нь тэдэнд амьдралдаа амжилт гаргахад шаардагдах чадвар ба зан чанаруудыг хөгжүүлэхэд тусалдаг.



Хөтөлбөрийн зорилгууд ба шаардлагууд нь *Аароны Санваартан: Бурханы Өмнө Хүлээсэн Үүргээ Биелүүлэх* нь удирдамжийн диконууд, багш нар, санваартнуудад зориулсан хэсгүүдэд дурдагдсан байгаа. Залуу эрэгтэйчүүд нь Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Шагналыг хүртэхийн тулд өөрсдийн эцэг эх ба пристийн зэрэгтний удирдагчдын хамт зорилго тавьж түүнийгээ биелүүлэхийн төлөө хамтран ажилладаг.

Залуу эрэгтэйчүүд нь зарим зорилгуудаа гэр бүлтэйгээ, зэрэгтний чуулгантай хамт эсвэл бие дааж биелүүлдэг. Жишээ нь: дикон нь 2 жилийн хугацаанд доорх зорилгуудыг биелүүлнэ.

Гэр Бүлээр: 7 зорилгыг гэр бүлийн хамт дэвшүүлэх

Чуулгантай: 7 зорилгыг зэрэгтний чуулгантай эсвэл Харилцан Сайжралтын хүрээнд дэвшүүлэх

Хувиараа: 32 зорилгыг бие дааж хэрэгжүүлэх

Үйлчлэлийн төсөл: Өөрийн сонголтоор

Залуу эрэгтэйчүүд маань зорилтуудаа тавихдаа доорх дөрвөн хөгжилтийг хамруулдаг: Сүнсний Хөгжил; Бие Бялдрын Хөгжил; Боловсролын, Хувийн, Мэргэжлийн Хөгжил; мөн Иргэний ба Нийгмийн Хөгжил.

Дараах бүдүүвч нь Аароны Санваартны биелэлтийн хөтөл-  
бөрийг хураангуйлдаг. Залуу эрэгтэйг хөгжил дэвшлээ  
бүртгэхэд нь зориулан залуу эрэгтэйчүүдийн удирдамжинд  
тус бүдүүвчийн хувийг оруулсан болно.

**БУРХАНЫ ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ТАНЫ ҮҮРГИЙГ БҮРТГЭХ ХУУДАС**

**Х**эсэг бүрийг биелүүлснээ зохих нүдэнд тэмдэглэ  
Хэсвэл нэрийн эхний үсгийг бич. Таныг дараах зүй-  
лүүдийн болзлыг гүйцэтгэхэд танай бишоп Бурханы  
Өмнө Хүлээсэн Үүргийн Биелэлтийн хуудсанд гарын  
үсэг зурна. Дараа нь та Бурханы Өмнө Хүлээсэн  
Үүргийн гэрчилгээг авч болно.

Санваарын Үүргүүд ба Жишгүүд	
Гэр Бүлийн Үйл Ажиллагаа	
Чуулгын Үйл Ажиллагаа	
Хувийн Зорилго	
Сүнсний Хөгжил	
Бие Бялдрын Хөгжил	
Боловсролын, Хувийн болон Ажил Мэргэжлийн Хөгжил	
Иргэний ба Нийгмийн Хөгжил	
Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Үйлчлэлийн Төсөл	
Миний Хувийн Тэмдэглэл	

## **Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Үйлчлэлийн Төсөл**

Залуу эрэгтэй бүр гэр бүл, хэсэг, гадас, мөн оршин суугаа газартаа туслах 3 чухал үйлчлэлийн төслийг хийж гүйцэтгэх ёстой. Нэг төсөл нь диконоор, нэг нь багшаар, нөгөө нь санваартнаар гүйцэтгэгдэх ёстой. Залуу эрэгтэй нь уг төслийг төлөвлөж, бэлтгэн, хэрэгжүүлэх ёстой. Бусад нь шаардлагатай бол тусална. Төслийг тухайн залуу эрэгтэйн эцэг эхчүүд болон чуулгын зөвлөлх баталсан байх хэрэгтэй.



## **Харилцан Сайжралтын Талаар Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Үйл Ажиллагаанууд**

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ба чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлүүд нь дараах 4-н хөгжил дэвшлийн хэсгүүдэд төвлөрөн Харилцан Сайжралтын үйл ажиллагаануудыг төлөвлөхөөр урамшуулагддаг: Сүнслэг Хөгжил; Бие Бялдрын Хөгжил; Боловсролын, Хувийн, Мэргэжлийн Хөгжил; мөн Иргэний ба Нийгмийн Хөгжил. Энэ нь залуу эрэгтэйчүүдэд Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Шагнал хүртэх зорилгуудаа биелүүлэхэд туслах болно.

## **Скаут**

Зарим орнуудад Скаут нь Аароны Санваартны үйл ажиллагааны хөтөлбөрийн нэг хэсэг болж Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөл ба Сүмийн Удирдлагаар сайшаагдсан. Үүний шалтгаан нь залуу эрэгтэйчүүдийг Аароны Санваартнаас Бурханы



Өмнө Хүлээсэн Үүргийн Хөтөлбөр ба Скаутын хөтөлбөрт оролцуулагдахаар дэмжигддэг.

Скаутын шаардлагуудыг Аароны Санваартнаас Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Хөтөлбөрийн маш олон харьцуулж болмоор хувийн зорилгуудыг биелүүлэхэд ашиглаж болно. Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Шагнал нь санваартны шагнал бөгөөд энэ нь залуу эрэгтэйчүүдийг сүнслэг байдлаа хөгжүүлж, пристийн зэрэгтний үүргээ биелүүлэхэд нь тусалж болох шаардлагуудыг агуулсан байдаг.

Скаут нь Сүмийн нэгэн хэсэг болж чадаагүй бүс нутгуудад, орон нутгийн санваартны удирдагчид нь дараах нөхцлөөр Скаутын хөтөлбөрийг үүсгэн байгуулж болно:

- Скаут нь Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөл болон Сүмийн Ерөнхий Скаутын Хорооны зөвшөөрөлтэйгээр хэрэглэгдэх ёстой.
- Скаутын хөтөлбөр нь Сүмийн бодлого, жишгүүд болон санаануудтай зохицсон байх ёстой.
- Скаут нь Скаутын Хөдөлгөөний Дэлхийн Байгууллагатай холбоотой байх ёстой ба Баден Паувелын Нөхөрлөлийн Зарчим дээр үндэслэгдсэн байх ёстой.

## **Гэрчилгээнүүд ба Шагнал**

Залуу эрэгтэй нь Бурханы Өмнө Хүлээсэн Үүрэг хэмээх гурван хэсэг бүхий гэрчилгээнүүдийг хүртэх ёстой. Үүнд: дикон, багш, санваартан (дикон гэрчилгээ, 36416; багш, 36417; санваартан, 36418 ) орно. Тэрээр Аароны Санваартан: Бурханы Өмнө Хүлээсэн Үүргээ Биелүүлэх нь гэсэн 3 удирдамжийн нэгнийх нь болзлуудыг биелүүлж дуусгах бүрт гэрчилгээ хүлээн авдаг. Бишопын зөвлөлийн гишүүд нь чуулгын уулзалт эсвэл санваартны нээлтийн үйл ажиллагаан дээр гэрчилгээ бүрийг гардуулж болно.

Залуу эрэгтэй нь Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн гэрчилгээнүүдийг гурвууланг нь хүлээн авахдаа тэрээр Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Шагналыг хүлээн авдаг. Тэрээр энэхүү шагналыг 19 насныхаа ойгоор хүлээн авах ёстой. Энэ шагнал нь гэрчилгээ, хүзүүний зүүлтээс бүрддэг. Бишопын зөвлөлийн гишүүн нь энэхүү шагналыг ариун ёслолын цуглаан дээр гардуулж болно.

Гэрчилгээнүүд ба хүзүүний зүүлтийг Сүмийн хангамжийн төвөөр дамжуулан хэсэг эсвэл салбарын хөрөнгөнөөс гаргаж авах бөгөөд залуу эрэгтэйчүүд эсвэл тэдний эцэг эхчүүдээс ямар ч зардал гарах ёсгүй.

### **Бүртгэл Хөтлөлт**

Залуу эрэгтэйчүүдийг өөрсдийн өсөлт дэвшлийн бүртгэл болгон удирдамжийн тэмдэглэл хөтлөхийг нь урамшуулан дэмжих хэрэгтэй. Чуулгын зөвлөхүүд зохих дэмжлэгээр хангахын тулд залуу эрэгтэй тус бүрийн өсөлт дэвшлийн энгийн бүртгэл хөтлөхийг хүсч болно (Аароны Санваартнаас Бурханы Өмнө Хүлээх Үүргийн Биелэлтийн Бүртгэл [36720]). Дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх шаардлагагүй.

### **Хувь Хүний болон Орон Нутгийн Хэрэгцээнд Нийцүүлэх нь**

Та хувийн болон тухайн нөхцөл байдал, хэрэгцээ сонирхлынхоо дагуу *Аароны Санваартан: Бурханы Өмнө Хүлээсэн Үүргээ Биелүүлэх нь* удирдамжуудад дурдсан шаардлагуудыг эцэг эх болон Аароны Санваартны удирдагчдаараа урьдчилан батлуулан өөрчлөх буюу сольж болно. Нэг хүнд зориулан ямар нэгэн өөрчлөлт хийхдээ эдгээр өөрчлөлт нь бусад залуу эрэгтэйчүүдэд үзүүлэх нөлөөг удирдагчид нь маш хянамгай бодолцох ёстой. Эцэг эх, удирдагчдын нарийн хэлэлцүүлгийн дараа өөрчлөлтүүд нь тахир дутуу эсвэл оюун санааны хомсдолтой залуу эрэгтэйчүүдийн хэрэгцээ, соёлын болон хувийн хэрэгцээг хангахад эсвэл гишүүн бус залуу эрэгтэйчүүдийг оролцохыг зөвшөөрсөн нийцтэй өөрчлөлтүүд байж болно.

Бурханы Өмнө Хүлээсэн Өмнөх Үүргийн гэрчилгээнүүдээс нэгийг нь буюу хоёуланг нь хүлээн аваагүй зохистой багш буюу санваартан нь (1) санваартны одоогийн гэрчилгээний бүх болзлуудыг мөн (2) гэр бүл ба чуулгын үйл ажиллагаанууд, хувийн зорилгуудаас гадна жил тутмын үйлчилгээний төсөл, яриа, гэр бүлийн үдшийн хичээл гэсэн шаардлагуудыг (өмнөх гэрчилгээнүүдийн шаардлагуудыг) биелүүлснээр Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Шагналыг хүртэх боломжтой байна.

### **Удирдагчдын Үүрэг Хариуцлага**

Бишопын зөвлөлийн гишүүд нь залуу эрэгтэйчүүдэд санваартных нь үүргийн талаар зааж, тэднийг Бурханы Өмнө Хүлээсэн Үүргийн Шагналыг хүртэхэд нь туслах үүрэгтэй. Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл нь Бишопын зөвлөлийн гишүүдэд тусалдаг. Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл нь залуу эрэгтэйчүүдэд чуулгын цуглаанууд болон үйл ажиллагаануудын үеэр чуулгад шаардлагатай зорилтоо биелүүлэх боломж өгсөн гэдэгт анхаарах ёстой.

Залуу эрэгтэй 12 нас хүрэхэд төрсөн өдрөөс нь өмнө бишопын зөвлөлийн гишүүн ба диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн нь залуу эрэгтэй болон түүний эцэг эхтэй уулзах ёстой. Тэд диконуудад зориулсан *Аароны Санваартан: Бурханы Өмнө Хүлээсэн Үүргээ Биелүүлэх* нь номын нэг хувийг түүнд өгч, үүргийг нь заах ёстой. Залуу эрэгтэйг багш болон санваартны албан тушаалд томилогдоход нь мөн үүний адил уулзах ёстой.

Бишопын зөвлөлийн гишүүдийг залуу эрэгтэй бүрийн хөгжил дэвшлийг шалгахын тулд залуу эрэгтэйчүүдтэй хуваарийн дагуу тогтмол ярилцлага хийж байхыг дэмждэг. Гадасны ерөнхийлөгчид нь бишопуудаасаа хэсгийнх нь залуу эрэгтэйчүүдийн хөгжил дэвшил ба халамжийн талаар тогтмол асууж лавлах ёстой.

# ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХУВИЙН ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ХӨТӨЛБӨР

## Тойм


**З**алуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөр нь залуу эмэгтэй бүрийг түүний төлөөх Бурханы хүслийг ойлгоход, Түүний зарлигуудыг дагах урам зоригийг түүнд өгөх, мөн түүнийг ариун сүмийн гэрээнүүдийг хийж дагахад нь бэлтгэхэд тусалдаг. Энэ нь түүнийг гэр бүлдээ өөрийн хувь нэмрийг одоо оруулах болон ирээдүйдээ итгэлтэй эмэгтэй, эхнэр, эх, мөн Сүмийн удирдагч байх үүрэг хариуцлагуудад бэлтгэх замыг бэлдэж өгдөг. Энэ нь түүнийг Залуу Эмэгтэйчүүдийн Батламжийг хүлээн авахад бэлтгэдэг.










Хөтөлбөрийн зорилго шаардлагууд нь *Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшил* номонд дурдагдсан. Залуу эмэгтэйчүүд нь эцэг эхчүүд болон Залуу Эмэгтэйчүүдийнхээ удирдагчидтай хамт Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх долоон чанарт үндэслэсэн зорилгуудыг биелүүлэхэд хамтран ажилладаг. Залуу эмэгтэй нь эрхэмлэх долоон чанар бүрт буй зургаан Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Туршлагуудыг хийж дуусгах ёстой. Эдгээр туршлагууд нь түүнд эрхэмлэх чанар бүрийг ойлгоход болон сайн мэдээний зарчмуудтай холбон үзэхэд нь туслах зориулалттай. Тэрээр юу сурснаа ашиглахын тулд 10 цагийн Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Төслийг хэрэгжүүлж дуусгах болно. Тэрээр мөн *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө*

гарын авлагад дурдагдсан жишгүүдийн дагуу амьдрахаар чармайх болно.

Дараах бүдүүвч нь Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөрийг хураангуйлдаг. Залуу эмэгтэйн хөгжил дэвшилд хяналт тавин мөрдөхөд зориулан *Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшил* номонд тус бүдүүвчийг оруулсан болно.



### ХУВИЙН ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

	 Итгэл	 Бурханлаг Мөн Чанар	 Хувь Хүний Үнэ Цэнэ	 Мэдлэг	 Сонголт ба Хариуцлага	 Сайн Үйлс	 Зарчимч Байдал
Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Турилага							
Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Турилага							
Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Турилага							
Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Турилага							
Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Турилага							
Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Турилага							
Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Төсөл							

Залуу Эмэгтэйчүүдийн Батламж \_\_\_\_\_

Он сар өдөр \_\_\_\_\_

Биелүүлсэн туршлагуудынхаа тоог дээрх нүднүүдэд бич.

## **Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Туршлага болон Төслүүд**

Залуу эмэгтэйчүүд Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөрт өөрийнхөө хэм хэмнэлээр ажиллаж болох боловч ахих явцаа зөв зохицуулан Залуу Эмэгтэйчүүдэд байх бүхий л хугацаандаа хөтөлбөртэй байхыг хичээх ёстой. Залуу эмэгтэйгээс жил бүр доод тал нь 9 туршлага ба төслийг хийж дуусгахыг хүсдэг.

Дараах нь Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Туршлага ба Төслүүдийг гүйцэтгэхэд зориулсан зааварчилгаанууд юм:

- Залуу эмэгтэйчүүд нь эрхэмлэх чанарууд дээр ямар ч дарааллаар ажиллаж болно. Тэд тэрхүү эрхэмлэх чанарт зориулсан төслийг хийхээс өмнө эрхэмлэх чанар дахь зургаан туршлагауудыг хийж дуусгах ёстой.
- Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Төслүүд нь хосолсон байж болохгүй. Гэсэн ч, хэрэв залуу эмэгтэй нь нэгээс илүү эрхэмлэх чанараас бүрдэх томоохон төслийг хийхээр сонгосон бол тэрээр эрхэмлэх чанар бүрт доод тал нь 10 цаг зарцуулах ёстой. Нэгээс илүү Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Төсөлд үүний адил 10 цагийг тоолж болохгүй.
- Залуу эмэгтэйчүүд нь төслүүд дээр хамтран ажиллаж болно. Гэвч, хэрвээ залуу эмэгтэй нь тэрхүү төслийг өөрийнхөө Хувийн Хөгжил Дэвшлийн хөтөлбөрт ашиглаж байгаа бол тэрээр өөрийн цагаас доод тал нь 10 цаг зарцуулах ёстой.
- Залуу эмэгтэйчүүдийн гэр, сүм, сургууль, семинарт болон амьдардаг газраа хийж буй сайн зүйлс нь эцэг эхчүүд ба Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчдын зөвшөөрөлтэйгээр Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөрийн шаардлагауудыг биелүүлж болно.

Хэрэв залуу эмэгтэй нь Нийгмийн Халамжийн Бүлэгт орохоосоо өмнө Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөрийг биелүүлсэн бол тэрээр Залуу Эмэгтэйчүүдэд үргэлжлүүлэн идэвхтэйгээр оролцож болно. Тэрээр нэмэлт Эрхэмлэх

Чанарыг Хөгжүүлэх Туршлагауд ба Төслүүдийг гүйцэтгэх, өөрийнхөө хувийн түүхийг эмхтгэх, Мормоны Номыг унших, удирдлагын үүрэг даалгавруудыг гүйцэтгэх, мөн Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөр дээрээ ажиллаж байгаа бусад залуу эмэгтэйчүүдэд тусалж болно.

Хэрэв залуу эмэгтэй нь Залуу Эмэгтэйчүүдийн бүлгээ орхиоос өмнө Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөрийн бүх шаардлагуудыг дуусгаагүй бол тэрээр 19 насныхаа төрсөн өдрийг хүртэл Залуу Эмэгтэйчүүдийн Батламжийг хүлээн авахын төлөө үргэлжлүүлэн ажиллаж болно.

### **Харилцан Сайжралт дахь Хувийн Хөгжил Дэвшлийн Үйл Ажиллагаанууд**

Хувийн Хөгжил Дэвшлийн үйл ажиллагаанууд нь Мючел үеэр үе үе зохиогддог. Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөр нь залуу эмэгтэй бүрийн хувьд урьдны адил хувийн байгааг баталж тиймэрхүү бүлгийн үйл ажиллагаануудыг залбиралтайгаар болон сонголттойгоор төлөвлөх ёстой.

### **Эмблем, Гэрчилгээ ба Батламж**

Залуу эмэгтэй нь эрхэмлэх чанар бүр дэх туршлага ба төслүүдийг гүйцэтгэж дуусгахдаа эмблем хүлээн авч номынх нь ард буй Хувийн Хөгжил Дэвшлийн Биелэлтийн Гэрчилгээндээ байрлуулдаг. Түүнд хөгжил дэвшлийн энэхүү батламжийг Залуу Эмэгтэйчүүдийн цуглаан дээр гардуулдаг.

Залуу эмэгтэй нь долоон эрхэмлэх чанарыг бүгдийг нь биелүүлээд бишоптойгоо ярилцлаганд орж Залуу Эмэгтэйчүүдийн Батламжийг хүлээн авдаг. Энэ батламж нь гэрчилгээ (36651) ба алт (алт,36652;) эсвэл мөнгөөр ( мөнгө, 36653) хийсэн Залуу Эмэгтэйчүүд гэсэн хүзүүний зүүлтээс бүрддэг. Бишопын зөвлөлийн гишүүн нь Залуу

Эмэгтэйчүүдийн Батламжийг ариун ёслолын цуглаан дээр гардуулж болно.

Шагнал ба гэрчилгээнүүдийг Сүмийн хангамжийн төвөөр дамжуулан хэсгийн хөрөнгөнөөс гаргах бөгөөд залуу эмэгтэйчүүд эсвэл тэдний эцэг эхчүүдээс ямар ч зардал гарах ёсгүй.

### **Удирдагчдын Хувийн Хөгжил Дэвшлийн Шаардлагууд**

Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөрт өөрсдөө оролцогч удирдагчид хөтөлбөрөө сайн ойлгож залуу эмэгтэйчүүдийн дагах сайн үлгэр жишээ болдог. Удирдагчид Залуу Эмэгтэйчүүдийн Батламжийг дараах зүйлсийг хийсний дараа хүртэж болно:

- Бүтэн нэг жил Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчаар үйлчлэх.
- Долоон эрхэмлэх чанар бүрийн гурван Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Туршлагауудыг биелүүлэх.
- Гурван Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Төслүүдийг гүйцэтгэх.

### **Хувь Хүний болон Орон Нутгийн Хэрэгцээнд Нийцүүлэх нь**

Та хувийн болон тухайн нөхцөл байдал, хэрэгцээ сонирхлынхоо дагуу Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Туршлага ба Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Төслүүдийг эцэг эх болон Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчдаараа урьдчилан батлуулан өөрчилж болно. Нэг хүнд зориулан ямар нэгэн өөрчлөлт хийхдээ эдгээр өөрчлөлт нь бусад залуу эмэгтэйчүүдэд үзүүлэх нөлөөг удирдагчид нь маш хянамгай бодолцох ёстой. Эцэг эхчүүд, удирдагчдын нарийн хэлэлцүүлгийн дараа өөрчлөлтүүд нь тахир дутуу эсвэл оюун санааны хомсдолтой залуу эмэгтэйчүүдийн хэрэгцээ, соёлын болон хувийн



хэрэгцээг хангахад эсвэл гишүүн бус залуу эмэгтэйчүүдийг оролцохыг зөвшөөрсөн нийцтэй өөрчлөлтүүд байж болно.

Хэрэв залуу эмэгтэй нь 16 наснаасаа хойш Сүмд нэгдэх эсвэл идэвхтэй болсон бол Хувийн Хөгжил Дэвшлийн Хөтөлбөр дэх түүний шаардлагууд нь (1) Бишоп буюу салбарын ерөнхийлөгч нь ярилцлаган дээрээ тодорхойлдог *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөөний* жишгүүдээр амьдрах; (2) долоон эрхэмлэх чанар бүр дэх гурван Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Туршлагауудыг гүйцэтгэх; мөн (3) долоон эрхэмлэх чанар бүр дэх Эрхэмлэх Чанарыг Хөгжүүлэх Төслийг гүйцэтгэх юм. Мөн орон нутгийн Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчдын шийдэх бусад нөхцөл байдлуудад залуу эмэгтэйчүүд эдгээр шаардлагыг хэрэглэж болно.

### **Удирдагчдын Үүрэг Хариуцлага**

Залуу эмэгтэйчүүдийн удирдагчид нь Залуу Эмэгтэйчүүдийн хөтөлбөрт элсэн орж буй эмэгтэй бүртэй болон түүний эцэг эхтэй уулзах ёстой. Мөн охидын ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн нь оролцож болно. Удирдагчид нь залуу эмэгтэйд *Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшлийн* номыг гардуулан түүнд хөтөлбөрийг тайлбарлах ёстой. Тэд эцэг эхчүүдийг охидоо Хувийн Хөгжил Дэвшлийн туршлагаууд ба төслүүдээс сонгох болон гүйцэтгэхэд хамтран ажиллахад нь урамшуулах ёстой. Мөн эцэг эхчүүдийг охиных нь оролцож буй бүх хөтөлбөрт урих ёстой.

Залуу эмэгтэй нь Хувийн Хөгжил Дэвшлийн хөтөлбөрийг бүхэлд нь хийж дуусахад бишоп нь *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөөг* жишгүүдийг удирдамж болгон түүнтэй ярилцлага хийдэг. Энэ нь түүний жилийн эсвэл 6-н сар тутмын ярилцлагынх нь нэг хэсэг болж чадна. Бишоп нь залуу эмэгтэйн Залуу Эмэгтэйчүүдийн Батламжийг хүлээн авах зохистойг нь тодорхойлдог.

Бишопын зөвлөлийн гишүүдийг залуу эмэгтэй бүрийн хөгжил дэвшлийг шалгахын тулд залуу эмэгтэйчүүдтэй хуваарийн дагуу тогтмол ярилцлага хийж байхыг дэмждэг. Гадасны ерөнхийлөгчид нь бишопуудаасаа хэсгийнх нь залуу эмэгтэйчүүдийн хөгжил дэвшил ба халамжийн талаар тогтмол асууж лавлах ёстой.



# Х А Р И Л Ц А Н   С А Й Ж Р А Л Т

## Зорилго

**З**алуу эрэгтэйчүүд ба залуу эмэгтэйчүүд нь тээврийн хэрэгсэл зэрэг бусад ямар нэгэн саадгүй л бол Харилцан сайжралт гэж нэрлэгддэг долоо хоног тутмын үдшийн үйл ажиллагаанд оролцох ёстой. Сайн зохион байгуулагдсан Харилцан Сайжралтын үйл ажиллагаанууд нь залуучуудын амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг. Харилцан сайжралт нь тэдэнд нийгмийн амьдралд оролцох, Ням гарагт заалгасан сайн мэдээний зарчмуудаа хэрэгжүүлэх, гэрчлэлүүдээ хүчирхэгжүүлэх, үйлчлэл үзүүлэх, ашиг тустай харилцаа холбооныхоо ур чадварыг хөгжүүлэх, мөн идэвх султай залуучуудад хүрч ажиллах боломж өгдөг. Мөн Харилцан Сайжралт нь тэднийг Бурханы Өмнө Хүлээх Үүргийн Шагнал ба Залуу Эмэгтэйчүүдийн Батламжийг хүлээн авахад нь тусалдаг.

## Төлөвлөлт

Бишопын зөвлөлийн удирдлаган дор хэсгийн Залуу Эрэгтэйчүүд ба Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд нь Харилцан сайжралтыг хянан зохицуулдаг. Тэдэнд



ангийн ерөнхийлөгчийн зөвлөл, зөвлөх, мэргэжилтнүүд тусалж болно. Тэдний төлөвлөгөөнүүд нь бишопын зөвлөлийн залуучуудын хорооны цуглаан дээр батлагддаг.

## **Харилцан Сайжралтын Бүтэц ба Давтамж**

Харилцан сайжралт нь Ням ба Даваа гарагаас бусад гар-гийн өдөр эсвэл орой зохиогддог бөгөөд боломжтой бол долоо хоногийн нэг тогтсон өдөр, цаг, адил газарт цуглах ёстой. Ерөнхийдөө, Харилцан Сайжралт нь 1 ба 1 ½ цаг үргэлжлэх ёстой бөгөөд дараах хэсгүүдэд хуваагддаг:

- Нээлтийн үйл ажиллагаа (10-15 минут)
- Анги болон чуулгын үйл ажиллагаа (30-75 минут)
- Дадлага эсвэл олон нийтийн үйл ажиллагаа (сонголтоор; 30 минут)

*Нээлтийн Үйл Ажиллагаа.* Бишопын зөвлөлийн гишүүн эсвэл Залуу Эрэгтэйчүүд ба Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн нь нээлтийн үйл ажиллагааг тэргүүлэн удирддаг. Лоорэл ангийн ерөнхийлөгчийн зөвлөл ба бишопын пристийн чуулгын туслахууд үргэлжлүүлэн удирддаг. Нээлтийн үйл ажиллагаанд сүмийн дуулал ба залбирал, яриа, хөгжмийн хөтөлбөр, шинэ дуу сурах, мөн залуучуудад өөрсдийнхөө авъяас билгээс болон гэрчлэлээс хуваалцах боломжууд орно.

*Ангийн буюу Чуулгын Үйл Ажиллагаа.* Аароны Санваартны болон Залуу Эмэгтэйчүүдийн хамтарсан үйл ажиллагаанууд нь сар бүр тогтмол нэг удаа зохион байгуулагддаг. Бусад долоо хоногууд нь Залуу Эмэгтэйчүүдийн ангийн үйл ажиллагаа ба Аароны Санваартны чуулгын тус тусынх нь үйл ажиллагаануудад зарцуулагдаж болно. Залуу Эмэгтэйчүүдийн ангиуд ба Аароны Санваартны чуулгуудын хамтарсан болон тэдний гэр бүл, эцэг эхчүүд нь оролцсон үйл ажиллагаанууд үе үе зохиогдож болно.

Заримдаа сард 5 долоо хоног байгаа үед хэсэг эсвэл салбарын үйл ажиллагаануудад гэр бүлийн бүх л гишүүд оролцдог. Тиймэрхүү үйл ажиллагаанууд нь үйл ажиллагааны хорооны удирдлаган дор зохиогдож болно.

- Сар тутмын Аароны Санваартны болон Залуу Эмэгтэйчүүдийн хамтарсан үйл ажиллагаа нь хэсгийн 12 - 18 насны бүхий л залуучуудад болзооноос өөр нөхцөл байдалд хамтдаа ажиллаж, сурч, мөн бие биенээ сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахад нь тусалж дэмжих боломжийг өгдөг. Энэхүү залуучуудын хамтарсан үйл ажиллагаануудыг бишопын зөвлөлийн залуучуудын хорооны цуглаан дээр хуваарь гарган хэлэлцэж бишопын зөвлөлийн удирдлаган дор хэрэгжүүлэх ёстой.
- Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагаа нь дараах олон талын төрөл бүрийн хэсгээс бүрдэх ёстой: үйлчлэл; гэр ахуй; хөгжим, яриа, жүжиг; бүжиг; утга зохиол ба гар урлаг; аялал зугаалга; спорт ба биенийн эрүүл мэнд; мөн Хувийн Хөгжил Дэвшил. Залуу Эмэгтэйчүүд нь тэднийг ирээдүйн гэр бүл, Сүм болон оршин суух газрынх нь үүргүүдэд бэлтгэх чадваруудад суралцах ёстой. Үйл ажиллагаанууд нь залуу эмэгтэй бүрийг Залуу Эмэгтэйчүүдийн Эрхэмлэх Чанаруудыг ойлгож хүлээн авахад нь туслах ёстой.
- Аароны санваартны үйл ажиллагаанууд нь залуу эрэгтэй бүрийг *Аароны Санваартан: Бурханы Өмнө Хүлээсэн Үүргээ Биелүүлэх* нь гэсэн удирдамж дээр дурдагдсан хөгжил дэвшлийн дараах 4-н хэсгээс түүнд өгөгдсөн туршлага нь түүнийг Аароны Санваартныхаа үүргийг биелүүлэхэд туслах ёстой. Үүнд: Сүнсний Хөгжил; Бие Бялдрын Хөгжил; Боловсролын, Хувийн, Мэргэжлийн Хөгжил; мөн Иргэний ба Нийгмийн Хөгжил.

Скаут нь байгаа болон Аароны Санваартны чуулгын үйл ажиллагааны нэг хэсэг нь болон ашиглагдахаар зөвшөөрсөн бүс нутгуудад залуу эрэгтэйчүүд нь энгэрийн таних тэмдэг, дэвших цол, мөн Скаутад заалгасан онцлог шинж чанаруудынхаа хөгжил дэвшлийн төлөө ажиллах ёстой.

*Дадлага буюу Харилцан Сайжралтын Үйл Ажиллагаа.* Мөн Мючелд залуу эрэгтэйчүүд ба залуу эмэгтэйчүүдийн анги болон чуулгын үйл ажиллагааныхаа дараа хамтдаа уулзах цаг мөч орж болно. Энэхүү цаг нь онцгой үйл явдалд зориулсан бэлтгэл сургууль хийх, спортын үйл ажиллагаанд оролцох эсвэл дадлага хийх, олон нийтийн жижиг хэмжээний үйл ажиллагаанд оролцох зэрэг юм.

### **Жил Тутмын Уриа**

Жил бүр Сүмийн удирдлагаас санваартны удирдагчдад залуу удирдагчидтай ярилцах Харилцан Сайжралтын жил тутмын уриаг санал болгосон мэдээллийг илгээдэг. Уриаг бүжиг, жүжиг, яриа, спорт, хөгжим, эсвэл үйлчлэл мэтийн үйл ажиллагаануудад голлон анхаарахад ашиглана. Үйл ажиллагаануудад зориулсан бэлтгэлүүдийг Харилцан Сайжралтын үеэр хийх ёстой.

### **Нэмэлт Эх Сурвалжууд**

*Үйл Ажиллагааны Ном* ( 31455 ) нь Санваартны Зорилгууд ба Залуу Эмэгтэйчүүдийн Эрхэмлэх Чанаруудыг батжуулах 300 гаруй үйл ажиллагааны санааг агуулдаг. Мөн Сүмийн сэтгүүлүүд нь Мючелийн үйл ажиллагаануудад зориулан ашиглах санаануудыг агуулсан байдаг.

Дараах нь Мючелийн үйл ажиллагааг төлөвлөхөд туслах зориулалттай хийх ажлыг тэмдэглэх хуудасны загвар юм:

## **Харилцан Сайжралтыг Төлөвлөх Ажлын Хуудас**

Энэхүү Харилцан Сайжралтын үдэш зохиогдох огноо: \_\_\_\_\_

### **Нээлтийн үйл ажиллагаа**

Тэргүүлэх: \_\_\_\_\_

Хөглөх: \_\_\_\_\_

Нээлтийн дуулал: \_\_\_\_\_

Нээлтийн залбирал: \_\_\_\_\_

Хөгжим (хөгжмийн хөтөлбөрүүд, шинэ дуу сурах):

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

Яриа(нууд): \_\_\_\_\_

\_\_\_\_\_

### **Ангийн буюу чуулгын үйл ажиллагаа**

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

### **Сурах буюу олон нийтийн үйл ажиллагаа (сонголтоор)**

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## УДИРДЛАГЫН ЗАРЧМУУДЫГ ЗАЛУУЧУУДАД ЗААХ НЬ

**З**алуу эрэгтэй ба залуу эмэгтэйн насанд хүрэхдээ бэлтгэх чухал хэсэг бол удирдах чадвар ба шинж чанарыг хөгжүүлэх юм. Өнөөдрийн залуучууд нь маргаашийн аав, ээж ба Сүмийн удирдагчид юм. Аароны Санваартны ба Залуу Эмэгтэйчүүдийн биелэлтийн хөтөлбөрүүдийн эн тэргүүний зорилго бол залуучуудад удирдагчийн ур чадвар, шинж чанаруудыг хөгжүүлэхэд туслах явдал юм.



Эцэг эхчүүд ба залуучуудын удирдагчид нь биелэлтийн хөтөлбөрүүдийг залуучуудад гэр, чуулга, ангидаа, мөн Мючелийн үйл ажиллагаануудад удирдагчийн туршлагатай болоход нь ашиглах ёстой. Жишээлбэл, залуучууд нь удирдах аргыг гэр бүлийн үдшийн хичээл заахад, гэр бүлийнхээ хичээлийг удирдахад, гэр бүлийн үйл ажиллагааг төлөвлөх эсвэл эрэгтэй, эмэгтэй дүү нартаа туслахдаа гэртээ сурч чадна. Мөн тэд удирдах аргыг санваартны чуулгууд ба Залуу Эмэгтэйчүүдийн ангиудынхаа үйл ажиллагааг төлөвлөх болон оролцоходоо суралцдаг. Удирдагчид нь залуучуудад удирдах туршлагыг олгох боломж бүрийг ашиглах ёстой.

Аароны Санваартны ба Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид нь удирдах чадварыг анги болон чуулгын ерөнхий-



лөгчийн зөвлөлүүдэд заах онцгой үүрэг хариуцлагатай. Эдгээр ур чадваруудыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглаан дээр зааж болно.

Дараах удирдлагын зарчмуудыг залуучуудад заах ёстой:

- Аврагчийн жишээг дагах.
- Удирдагчийн зан чанарын онцлог шинжийг хөгжүүлэх:
  - Итгэл
  - Хайр
  - Дуулгавартай байдал
  - Эв нэгдэл
  - Золиослол
- Удирдагчийн үүрэг даалгавруудыг биелүүлэх:
  - Зүг чигийг эрж хайх ба зорилго тавих.
  - Төлөвлөх ба даалгах.
- Хэлэлцэх асуудлыг бэлтгэх ба хэрэглэх.
  - Цуглааныг үр дүнтэй хөтлөх.
  - Зөвлөлийг үр дүнтэй удирдах ба оролцох.
  - Нууц хадгалах.

Залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд удирдлагын зарчмуудыг заахад нь эцэг эхчүүд, удирдагчдад туслах эх сурвалжууд бол *Church Handbook of Instructions, Book 2*, бүлэг 16 “*Gospel Teaching and Leadership: Priesthood and Auxiliary Leaders*” (35209) болон *Санваартны болон Хавсралт Байгууллагуудын Удирдагчдын Удирдамж* (31178) юм.

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN



4 02366 79363 1

36679 363